

ТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

D.Urantsetseg@must.edu.mn

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ГЭЖ ЮУ ВЭ?

“Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод санаачилсан. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-ЫН ХАМРАХ ХҮРЭЭ



НИЙГЭМ





ЭДИЙН ЗАСАГ



БАЙГАЛЬ ОРЧИН

Хөгжлийн эдийн засаг нь янз бүрийн үзэл баримтлал, учир шалтгаантай, эдийн засгийн нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай шинэ санаа, шинэ хандлагыг бий болгоход чиглэсэн, орчин үеийн буурай хөгжилтэй гуравдагч орнуудын тухай шинжлэх ухаан бөгөөд үндэслэгч нь 1979 онд Нобелийн шагнал хүртсэн Артур Луйс, Теодер Шульц нар юм. Хөгжлийн эдийн засгийн гол зорилго нь дэлхийн хүн амын 2/3-ын материаллаг амьдралыг дээшлүүлэхийн тулд гуравдагч ертөнцийн эдийн засгийг сайтар ойлгож, танин мэдэхэд туслахад оршино.



ХӨГЖЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- 1.Амьжиргааны түвшин дээшилсэн**
- 2.Эдийн засаг өссөн**
- 3.Аж үйлдвэржилт**
- 4.Эдийн засгийн бие даасан байдал**
- 5.Ядуурлын түвшин буурсан**
- 6.Тогтвортой хөгжил**
- 7.Хүний хөгжил**

ҮЙЛ АЖИЛЛАГАА 4.30

Сурах бичиг- 130 хуудас

1. Дэлхийн банкны атласын аргаар нэг хүнд ногдох ҮНО-д үндэслэн улс орнуудыг орлогын түвшнээр дараах үндсэн 4 бүлэгт хувааж байгаа бөгөөд манай улс орлогын аль бүлэгт хамаарагдаж байна вэ? Үүнд:
 - Бага орлоготой, 1.005\$-оос бага;
 - Дунджаас доогуур орлоготой, 1.006–3.955\$;
 - Дунджаас дээгүүр орлоготой, 3.956–12.235\$;
 - Өндөр орлоготой, 12.236\$ ба түүнээс дээш
2. Манай улсын ҮНО-ын хэмжээг дараах загвар хүснэгтийг ашиглан холбогдох сайтаас авч, баганан диаграммаар илэрхийлж, ямар хандлагатай байгааг тайлбарлана уу.

Монгол улсын хувьд нэг хүнд ногдох ҮНО


Үзүүлэлт	2016	2017	2018	Жилийн өсөлтийн дундаж хурд
ҮНО, ам.доллараар.				

**НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНООС (2021.03.18)
ТАНИЛЦУУЛСАН ТАЙЛАНД МОНГОЛ УЛС АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКСЭЭР 5.6 ОНООГООР
ДЭЛХИЙН 149 УЛСААС 70-Д ЖАГССАН БАЙНА.**

Дэлхийн хамгийн аз жаргалтай улсаар Финланд улс (7.8 оноогоор) Исланд, Дани, Швейцар, Нидерланд улсууд жагсчээ. Дэлхийн хамгийн аз жаргалгүй улсуудаар Энэтхэг, Бурунди, Йемен, Танзани, Гаити, Малави, Зимбабве, Афганистан зэрэг улсууд нэрлэгдсэн байна.






ДЭЛХИЙН ИНТЕГРАЦИЙН ҮНДСЭН БҮЛГҮҮД



ДАЯАРШЛЫН ҮЕИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

**ЧӨЛӨӨТ
ХУДАЛДАА**

МӨНГӨ УГААХ



1. Төр эдийн засгаа тогтворжуулахын тулд хэд хэдэн бодлогыг авч хэрэгжүүлдэг. Тэгвэл эдгээрээс төрийн эдийн засгийн үндсэн хоёр бодлого нь аль вэ?
 - а.Сангийн ба мөнгө зээлийн бодлого
 - б.Татварын ба ажил эрхлэлтийн бодлого
 - в.Хүүгийн ба гадаад худалдааны бодлого
 - г.Гаалийн ба хөрөнгө оруулалтын бодлого
2. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу? Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг төрийн гэнэ.
 - а.Хүүгийн бодлого
 - б.Сангийн,төсвийн бодлого
 - в.Мөнгө,зээлийн бодлого
 - г.Татварын бодлого
3. Төр татвараас гадна тодорхой төрлийн барааны импортод хязгаарлалт буюу квот тогтоож өгөх тохиолдол байдаг. Жишээ нь: Тухайн оронд жилд орох барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс, 100 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Ийм арга хэмжээг гадаад худалдааны ямар бодлого гэж нэрлэдэг вэ?
 - а.Капиталын бодлого
 - б.Демпинг
 - в.Санхүү мөнгөний бодлого
 - г.Протекционист бодлого
4. Олон улсын эдийн засагт улс орнуудын эзлэх байр суурийг тодорхойлдог шалгууруудыг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?
 - а.Эдийн засгийн бодлого
 - б.Эдийн засгийн хөгжлийн түвшин
 - в.Эдийн засгийн бүтэц
 - г.Эдийн засгийн өсөлтийн төрөл

ТЕСТ АЖИЛЛАХ